Үндсэн хөрөнгө данс 2022 онд барилга байгууламж, орон сууц 65,719.0 мянган төгрөг, тээврийн хэсэгсэл 226,485.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 158,508.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 44,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 50,719.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 154,176.0 мянган төгрөгийн тээврийн хэсэгсэл, 37,916.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 12,200.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 15,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 116,309.0 мянган төгрөгийн тээврийн хэсэгсэл, 120,593.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,255,670.0 мянган төгрөг болж 1,180,459.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,259,706.5 мянган төгрөгөөр тооцон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна.

Засаг даргын Тамгын газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,259,706.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дүгээр сарын 15-ны 05 дугаар тогтоолоор баталсан. Энэ нь үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлыг 275,588.6 мянган төгрөг, баг, хорооны үйл ажиллагааны арга хэмжээний зардлыг 69,853.4 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 50,059.6 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгө 5,000.0 мянган төгрөг, хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх зардал 4,470.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 854,735.0 мянган төгрөг тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн дүнгээр буюу орон нутгийн төсвөөс 1,259,706.5 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,259,706.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр нийт 1,259,706.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,188,373.7 мянган төгрөг буюу 94,3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 5,939.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 3,268.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 87.6 мянган төгрөг, томилолтын зардал 309.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1196.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 60,551.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Үндсэн үйл ажиллагааны зардал	275,588.6	267,936.7	7,651.9	97,2
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	50,059.6	48,178.6	1,881.0	96,2
3	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Баг, хорооны ҮАЗардал	69,853.4	68,604.1	1,249.3	98,2
4	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Бусад	854,735.0	794,184.0	60,551.0	92,9
5	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Баяр наадам	5,000.0	5,000.0	0	100
6	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага- 'Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	4,470.0	4,470.0	0	100
	Дүн	1,259,706.6	1,188,373.7	71,322.9	94,3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд усны нөхөн төлбөр 1,671.8 мянган төгрөг, ХАА-н тооллого судалгааны санхүүжилт 4,940.9 мянган төгрөг, халдварт өвчний шатахууны үнэ 1,555.2 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн ажлаас чөлөөлөгдсөн тэтгэмж 6,343.2 мянган төгрөг, ЭМТ-ийн барилгын санхүүжилт 150,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны үр дүнгийн болон тусламжийн орлого 5,126.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 12,353.9 мянган төгрөг, өвсний үнэ 14,666.8 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 29,122.3 мянган төгрөг, тэтгэлэг болон бусад 3,951.2 мянган төгрөг, улсын тэргүүний сумын шагнал 100,000.0 мянган төгрөг, нийт 329,731.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар тээвэр шатахуунд 3,281.4 мянган төгрөг, урсгал засвар 1,147.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 1,094.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 188,321.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 95,556.6 мянган төгрөг, нийт 289,400.67 мянган төгрөг зарцуулж, 40,330.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлагыг хангах	ОН-ын гүйцэтгэх засаглалын хөтөлбөр 98.2 %	1,255,236.60	1,183,903.67
2	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хангах	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хангах хөтөлбөр 95,2%	4,470.0	4,470.0

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 94,4% буюу 5,6%-иар дутуу хэрэгжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 447,732.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,712.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,372.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ нь тайлант онд төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд түлш халаалт 3,268.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 87.6 мянган төгрөг, томилолтын зардал 309.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1,196.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 60,551.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 5.0 сая төгрөгөөс дээш 129,159.5 мянган төгрөгийн 7 гүйлгээг нийт 48 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим”-ыг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн, явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/64 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,576.9	1	1,576.9	100
Албан шаардлага	7	145,571.9	7	145,571.9	100
Зөвлөмж	1				0
Нийт дүн	9	147,148.8	8	147,148.8	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын бараа материалын бүртгэл, зарцуулалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 794,158.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Цалингийн урьдчилгаа, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний 30 хувийн урьдчилгаа 13,500.0 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгэсэн, цалингаас суутгасан 103,753.7 мянган төгрөгийн ХХОАТ, НДШ-ийг цалингийн өглөг дансанд бүртгээгүй, гарт олгосон цалинг улирлаар нь бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Ахуйн үйлчилгээний барилгын урьдчилгаа төлбөр 615,907.6 мянган төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тус байгууллага нь 26,843.4 мянган төгрөгийн түлш шатахууныг авсан тухай бүрд бүртгэлгүй бөөн дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад барилга, байгууламж, орон сууц 15,000.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 19,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, шинээр нэмэгдсэн 2 үндсэн хөрөнгөнд 154.1

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 318,236.4 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² 200,845.2 мянган төгрөгийн зөвлөмж, 489.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 116,901.8 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.2 Төлбөрийн акт

Автотээрийн хэрэгслийн улсын үзлэг оношлогоог зохион байгуулах зардал 100.0 мянган төгрөгийг давхардуулан гаргасан зөрчил илэрлээ. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

ЗДТГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн Б/47 дугаар тушалаар Нийгмийн даатгалын байцаагч шинэ байранд орсонтой холбогдуулан 150.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон зөрчил илэрлээ. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Сахилгын шийтгэл ногдуулсан, шийтгэлтэй албан хаагчдад 239.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” журмын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн 28,528.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

НДШ-ийг ажил олгогч төлж тайлагнаагүй зөрчилд нийгмийн даатгалын улсын байцаагчийн тавьсан актын алданги 291.7 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад 3,081.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилогдсон тооллогын комисст тооцооны нягтлан бодогчийг оруулсан, комисс нь тооллого хийсэн гэх боловч тооцоо бодоогүй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Ахуй үйлчилгээний барилгын гадна тохижилтын 85,000.0 мянган төгрөгийн нэмэлт ажлын төсвийг ИТХ-аар батлуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т “Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 200,845.2 мянган төгрөгийн өртгөтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгаа, Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлгөөний 30 хувийн урьдчилгааг өглөг дансанд бүртгэсэн.	1	13,500.0			1	13,500.0	1	13,500.0
Ахуйн үйлчилгээний барилгын урьдчилгаа төлбөрийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн.	1	615,907.6			1	615,907.6	1	615,907.6
Түлш шатахууныг авсан тухай бүрд бүртгэлгүй бөөн дүнгээр бүртгэсэн.	1	26,843.4			1	26,843.4	1	26,843.4
Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад барилга, байгууламж, орон сууц 15,000.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 19,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Тушаалаар томилогдсон тооллогын комисс нь тооллого хийсэн гэх боловч тооцоо бодоогүй, илтгэх хуудас дүгнэлт гаргаагүй байна.	1	34,000.0			1	34,000.0	1	34,000.0
Тайлант онд 38,013.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 2 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	154.2			1	154.2	1	154.2
Цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийг цалингийн өглөг дансанд бүртгээгүй, гарт олгосон цалинг улирлаар нь бүртгэж тайлагнасан байна.	1	103,753.7			1	103,753.7	1	103,753.7
Дүн	6	794,158.9	0	-	6	794,158.9	6	794,158.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна	28,528.4	-	28,528.4	-
ЗДТГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн Б/47 дугаар тушалаар Нийгмийн даатгалын байцаагч шинэ байранд орсонтой холбогдуулан дэмжлэг олгосон байна.	150.0	150.0	-	-
ИТХ-аар төсвийг нь батлуулаагүй Ахуйн үйлчилгээний барилгын нэмэлт ажилд хөрөнгө нэмж зарцуулсан байна.	85,000.0	-	85,000.0	-
Автотээрийн хэрэгслийн улсын үзлэг оношлогоог зохион байгуулах зардлыг давхардуулан гаргасан байна.	100.0	100.0	-	-
Бараа материаллын үлдэгдлийн тооллого хийж тооцоо бодоогүй байна.	3,081.7	-	3,081.7	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 200,845.2 мянган төгрөгийн өртгөтэй 1078 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	200,845.2	-	-	200,845.2
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	239.4	239.4	-	-
Нийгмийн даатгалын улсын байцаагчийн тавьсан актын алдангийг төсвийн хөрөнгөөр төлсөн	291.7	-	291.7	-
Дүн	318,236.4	489.4	116,901.8	200,845.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 5.0 сая төгрөгөөс дээш 129,159.5 мянган төгрөгийн 7 гүйлгээг нийт 48 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	129,159.5	-	129,159.5	-